



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/690

Мөрөн сум

Эрүүл мэндийн салбар зөвлөл
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1."Эрүүл мэндийн салбар зөвлөл"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.
- 2.Батлагдсан зөвлөлийн бүрэлдэхүүн аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг хурлаар хэлэлцэн шийдвэрлэж ажилсугай.
- 3.Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд салбар дундын оролцоог ханган ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Салбар зөвлөлийн дарга :Аймгийн Засаг дарга

Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга : Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Салбар зөвлөлийн гишүүд:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн бодлого үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын дарга
- Нэгдсэн эмнэлгийн захирал
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн удирдлагын хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
- Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
- Зооноз өвчин судлалын төвийн дарга
- Нэгдсэн эмнэлгийн Төлөөллийн удирдах зөвлөлийн дарга
- Хувийн хэвшлийн эмнэлгүүдийн холбооны төлөөлөл
- Өрхийн эмнэлгүүдийн холбооны төлөөлөл
- Сумын эмч мэргэжилтний холбооны төлөөлөл
- Эм холбооны төлөөлөл
- Ахмад эмч нарын төлөөлөл

_____оОо_____